

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2016 оны 08 дугаар  
сарын 15-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго  
үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх зээл  
авах, зээлийн барьцаа хөрөнгийг компанийн үндсэн  
хөрөнгөөс гаргах эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.10 дугаар заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.6 дугаар заалт, Засгийн газрын 2016 оны 04 сарын 18-ны өдрийн 219 дугаар тогтоол, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 10.10.5 дугаар заалтыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражовего (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж авахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т зөвшөөрсүгэй.
2. Тус зээлийн барьцаанд шаардлагатай хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ТӨМӨРПҮРЭВ

